



Аймаг, нийслэлийн Боловсрол Соёлын Газруудын хооронд зохиогдох “Байгаль орчны боловсрол ба Тогтвортой хөгжил” сургалт зохион байгуулах уралдаан

Уралдааны зорилго:

Ерөнхий боловсролын сургуулиудын Байгаль орчны тухай мэдлэг, чадвар эзэмшүүлэх сургалтын чанарыг сайжруулах, хичээл хоорондын холбоо болон багш нарын хамтын үйл ажиллагааг улам нэмэгдүүлэх, сурагчдад цогц чадамж төлөвшүүлэх зорилгоор БСШУЯ, БОЯ, Дэлхийн байгаль хамгаалах сан (WWF)-гийн Монгол дахь хөтөлбөрийн газар хамтран аймаг, нийслэлийн Боловсрол, Соёлын Газар (БСГ)-уудын дунд “Байгаль орчны боловсрол ба тогтвортой хөгжил” сургалт зохион байгуулах уралдаан зарлаж байна.

Энэхүү уралдаан нь багш нар байгаль орчныг хамгаалах, тогтвортой хөгжлийн боловсрол эзэмших арга зүйд суралцах, багш нарын мэргэжил дээшлүүлэх сургалт байх нь тохиромжтой. Уралдааныг хэрхэн зохион байгуулах, ямар өвөрмөц, шинэлэг аргыг хэрэглэн ямар тусгай хөтөлбөрөөр явуулах нь тус сургалт, семинарыг явуулж байгаа БСГ-дын санаачлага байх болно.

Хамрах хүрээ:

Аймаг, нийслэлийн БСГ-ууд

Явагдах хугацаа:

2006 оны 10-р сараас 2007 оны 3-р сар хүртэл

Уралдаанд тавигдах шаардлага:

- Аймаг, хотын БСГ-ууд нь Дэлхийн байгаль хамгаалах сан (WWF)-гийн Монгол дахь хөтөлбөрийн газраас Шведийн олон улсын хөгжлийн хамтын ажиллагааны агентлаг (SIDA)-ийн санхүүжилттэй хэрэгжүүлж буй “Байгаль орчны боловсрол” дэд төсөлд хамрагдан ажиллаж байгаа сургагч багш нарын тусламжтайгаар аймаг, хотын сургуулиудад “Байгаль орчин ба Тогтвортой хөгжлийн боловсрол” сэдэвт сургалт, семинарыг хамгийн үр дүнтэй, сайн зохион байгуулах арга, хэлбэрийг сонгон, хөтөлбөрийг боловсруулж явуулна.

- Сургалт, семинарын хөтөлбөр нь байгаль болон хүрээлэн буй орчин, экологийн боловсролыг эзэмшүүлэхэд чиглэгдсэн төдийгүй сурагчдад цогц чадамж төлөвшүүлэх, агуулгыг интеграцлах, залгамж холбоог сайжруулах зорилгоор хийгдсэн байна.
- Зохиогдсон сургалт, семинарын агуулга, материал нь бусад багш нар ашиглаж, хэрэглэж болохуйц байх ба цаг үетэйгээ нийцсэн, ойлгомжтой, шинжлэх ухааны тодорхой түвшинд хийгдэнэ.

Уралдаанаас гарах үр дүн:

Ерөнхий боловсролын сургуулийн багш нарын дунд зохиох сургалтын үйл ажиллагааг чанаржуулах, сургалтын чиглэлийг боловсрол дах олон нийтийн оролцоог нэмэгдүүлэх, ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгт сургалтын үйл ажиллагааг шинэлэг, бүтээлчээр явуулах боломжийг бүрдүүлэх, даяарчилал, дангаарчилалын зохистой харьцааг бий болгох арга замыг нээн илрүүлэх зорилгод нийцүүлсэн хандлага, хэвшилтэй болгоход оршино.

Шагнал:

1-р байр (нэг)	диплом, 1,000,000 төг
2-р байр (нэг)	диплом, 650,000 төг
3-р байр (нэг)	диплом, 350,000 төг

Үнэлгээ:

Уралдааны явцад БСШУЯ, БОЯ зохих үнэлгээ өгөх бөгөөд 2007 оны 3-р сарын 31-ний дотор Дэлхийн байгаль хамгаалах сан (WWF)-гийн Монгол дахь хөтөлбөрийн газар уралдааны хөтөлбөр, холбогдох материалыг хүлээн авч, тусгай комиссын бүрэлдхүүнтэйгээр байр эзлүүлж дүгнэнэ.

Уралдаантай холбоотой асуудлаар дараах хүмүүстэй холбоо барьж болно.

- Ч.Эрдэнэчимэг (Дэлхийн байгаль хамгаалах сан (WWF)-гийн Монгол дахь хөтөлбөрийн газрын ажилтан)
 - 319985, 9982-3444, e-mail: erdenechimeg@wwf.mn
- Д.Мөнхжаргал (Нийслэлийн боловсролын газрын аргазүйч)
 - 310561 (12), 9918-2993, e-mail: ddaramm@yahoo.com

Боловсрол, соёл, шинжлэх ухааны яам

Байгаль орчны яам

*Дэлхийн байгаль хамгаалах сан (WWF)-гийн
Монгол дахь хөтөлбөрийн газар*